



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/47

Хараат

Малын түүвэр судалгаа явуулах тухай

Монгол Улсын "Статистикийн тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн В дэх заалт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйл, аймгийн Засаг даргын 2019 оны 1/652 дугаар албан бичгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2019 оны хагас жилийн малын түүвэр судалгааг явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга: -Д.Буджав (Сумын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: -Ё.Мядагмаа (Санхүү албаны дарга)

Гишүүд: -Г.Жаргалмаа (1 дүгээр багийн Засаг дарга)

-И.Эрдэнэбат (2 дугаар багийн Засаг дарга)

-Г.Дэмбэрэлжав (3 дугаар багийн Засаг дарга)

-Д.Мягмардорж (4 дүгээр багийн Засаг дарга)

-Т.Өлзийбат (Малын эмнэлгийн дарга)

2.Малын түүвэр судалгааг 2019 оны 06 дугаар сарын 03-аас 06 дугаар сарын 10-ны хооронд зохих журам, удирдамжийн дагуу чанартай үнэн зөв, малыг биечлэн үзэж тооллогод хамруулахыг тооллогын комиссын бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.тооллогын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж, зардлыг зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг Санхүү албаны дарга (Ё.Мядагмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БУДЖАВ

